

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ 02 ДҮГЭЭР
САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын
албаны үйл ажиллагааны мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 12 дугаар хуралдааныг 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хуралдуулж, дараах асуудлуудыг хэлэлцүүлэв.

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийн бүрэлдэхүүнийг улируулан сонгох тухай
2. “Нээлттэй Архангай” хөтөлбөрийг хэлэлцэн батлах тухай
3. Аймгийн “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлэлт өгөх тухай
4. Аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх тухай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

“Архангай Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл” цахим хуудсанд 10 мэдээ, 3 контент оруулан 10370 хүнд хүргэсэн байна.

“Архангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” цахим хуудсанд 20 фото мэдээ, 2 үйл явцын мэдээ, 2 контент оруулан 37021 хүнд хүргэсэн байна.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын шинэ тогтолцоо үүсэж хөгжсөний 30 жилийн ойн арга хэмжээний сэтгүүлийн бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтэнд “Бид танд туслана” ТББ хяналт хийж, иргэд болон анх удаа сонгогдсон эмэгтэй төлөөлөгчдөд сургалт хийн хэлэлцүүлж гарсан тайлан, дүгнэлтийг Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэв.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн “Архангай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ-83.3, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ-88.98, Мэдээллийн ил тод байдлын үнэлгээ-85.74 хувьтай үнэлэгдсэн.

Монгол Улсын “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн төлөвлөлтийн шийдлийг олон нийтээр хэлэлцүүлээ. Хэлэлцүүлгээр олон нийтээс ирэх санал, оновчтой шийдлийг төсөлд тусган хот байгуулалтын салбарын урт хугацааны нэгдсэн бодлогын баримт бичигт тусгаж, боловсронгуй болгоход чиглэгдэж байгаа юм. Хэлэлцүүлгийг Барилгын хөгжлийн төвийн БНХСТХ-ийн хэлтсийн дарга С.Даваанямаар ахлуулсан Барилга, хот байгуулалтын яам, ГЗБГЗЗГ-тай хамтарсан баг Архангай аймгийн Эрдэнэбулган суманд хоёрдугаар сарын 14-ны өдөр зохион байгууллаа.

Нээлттэй Архангай хөтөлбөрийг боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлууллаа.

2023 оны 02 дүгээр сарын 16-ны өдөр аймгийн удирдах ажилтны 2023 ээлжит шуурхай зөвлөгөөнийг агентлаг, төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын дарга, сумдын Засаг дарга нарыг оролцуулан өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулж өвөлжилтийн нөхцөл байдал, аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн бэлтгэл ажил, төрийн албаны сул орон тоо, ерөнхий болон тусгай шалгалт, 2023 онд Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудын зураг төсөв, он дамжсан хөрөнгө оруулалтуудын явцын талаарх мэдээллийг хүргээд тодорхой чиглэлээр үүрэг даалгавар өгч ажиллаа.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Төсвийн орлого

2023 оны 02 дүгээр сарын 24-ны өдрийн дүнгээр улсын төсвийн орлогод өссөн дүнгээр 469,140,620.78 төгрөг төвлөрүүлэхээс 522,135,809.23 төгрөг төвлөрүүлж, биелэлт 111,3 хувь, аймгийн төсвийн орлогод өссөн дүнгээр 208,773,000.0 төгрөг төвлөрүүлэхээс 214,986,594.38 төгрөг төвлөрүүлж, биелэлт 103,0 хувь, сумын төсвийн орлогод өссөн дүнгээр 1667981,5 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1748893,5 мянган төгрөг төвлөрүүлж, биелэлт 104,9 хувь байна.

Тендер, худалдан авах ажиллагаа

Орон нутгийн өмчийн газраас 2 дугаар сард 2927.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгууллаа. (Хот тохижилт, үйлчилгээний газар-150.0 сая, Цагдаагийн газар-138.3 сая, Нэгдсэн эмнэлэг- 2638,7 сая)

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр 5 төсөл арга хэмжээний худалдан авалтыг төсөл арга хэмжээ хэрэгжих нутаг дэвсгэрийн Төсвийн Ерөнхийлөн захирагчид эрх шилжүүлээ.

Орон нутгийн төсөвт өмч хувьчлалын орлогоор 23.3 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажиллаа.

Хөрөнгө оруулалт

2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 108,850,8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 50 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан бөгөөд 77,017,4 сая төгрөгийн 36 төсөл арга хэмжээний эрх шилжиж ирсэн.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 4,278,3 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээ, орон нутгийн хөрөнгийн их засвараар 1,664,1 сая төгрөгийн 24 төсөл арга хэмжээ тус тус хэрэгжихээр батлагдсан.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Гамшиг осол

2023 оны 01 дүгээр сард гамшиг, аюулт үзэгдэл, ослын дуудлага нийт 9 удаа гарснаас, объектын гал түймэр 5, гал түймрийн зөрчлийн дуудлага 2, мал, амьтны гоц халдварт мялзан өвчин 1, эрэн хайх, аврах ажиллагааны дуудлага тус тус 1 гарсан.

Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хүрээнд үзлэг шалгалт зохион байгуулж 15 зөрчил илрүүлж, зөрчил дутагдлыг бүрэн арилгуулж, холбогдох журмын дагуу ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг олгосон.

Монгол Улсын Шадар сайдын баталсан “Өвөлжилт, хаваржилт хүндрэх болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Монгол Улсын Их хурлын гишүүн, төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нар Архангай аймагт ажиллаж, 3 суманд өвөлжилтийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцан онцгой комиссын өргөтгөсөн хуралдааныг зохион байгуулж, холбогдох асуудлуудыг шийдвэрлэж ажиллалаа.

Гэмт хэрэг

Шүүхийн шинжилгээний албанаас мөрдөгч, прокурорын тогтоолоор эрүүгийн 5-н хэрэгт криминалистикийн шинжилгээ хийсэн бол хэргийн газрын үзлэгт-8, хүний амь нас хохирсон-8, зам тээврийн осол-1 гэсэн тоон үзүүлэлттэй бүрэлдэхүүнтэй шинжилгээ хийжээ. Мөрдөн шалгах бусад ажиллагаа болох цогцосны үзлэг-10, задлан шинжилгээ-10 тус тус хийж, хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ-19, бусад төрлийн шинжилгээнээс 0-17 насны хүнд бэлгийн холбогдолтой шинжилгээ-1 тус тус хийсэн байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээ

Улсын бүртгэлийн хэлтэс нь аймгийн хэмжээнд иргэдэд тоон гарын үсэг олгож, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2023.02.25-ны байдлаар дараах бүртгэлийг хийж гүйцэтгэжээ.

- Төрсний бүртгэл – 110
- Овог эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл - 3
- Эцэг /эх/ тогтоосны бүртгэл - 2
- Гэрлэсний бүртгэл - 23
- Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл- 6
- Үрчилсний бүртгэл - 1
- Нас барсны бүртгэл – 44
- Шинээр иргэний үнэмлэх олгосон - 101
- Дахин олгосон – 59
- Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 178 бүртгэл хийгдсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 476 иргэн, хуулийн этгээдээс мэдүүлгийг хүлээн авч, бүртгэлийг хийж гүйцэтгэжээ.

- Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл -11
- Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 22
- Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл –26
- Худалдах худалдан авах гэрээ – 67
- Бэлэглэлийн гэрээ – 8
- Барьцааны эрхийн бүртгэл – 296
- Өв залгамжлал – 10
- Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 11
- Лавлагаа – 3
- Бусад эрхийн бүртгэл – 7

Хууль хяналтын байгууллагад нийт 17 лавлагааг гарган хүргүүлсэн байна. Дээрх бүртгэлүүдийг хийж улсын төсөвт үйлчилгээний хөлс 4.060.062 тэмдэгтийн хураамжид 660.203 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 33.169.437 төгрөг төвлөрүүлсэн байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Эрүүл мэнд

Аймгийн нэгдсэн эмнэлэгт нэн шаардлагатай байсан хавдрын эрт илрүүлгийн явуулын амбулаторыг УИХ-ын гишүүдийн зүгээс Улсын төсвөөр шийдвэрлүүлж, хавдрын эрт илрүүлгийн явуулын авто машиныг, шаардлагатай тоног төхөөрөмжийн хамт хүлээлгэн өгсөн.

Хайрхан суманд “Эрчүүдийн эрүүл мэнд” өдөрлөгийг Эрүүл мэндийн газраас зохион байгуулж, сумын 80 гаруй эрэгтэйчүүд оролцож, эрүүл мэндийн мэдлэгээ дээшлүүлж, Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдсан.

Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь 2023 оны 1, 2 дугаар сард гэрээт 77 байгууллагуудад 2.337.234.304 төгрөгний зардлыг чанар төлбөрийн хяналтаар олгохоор тооцож шилжүүлсэн. Гэрээт 42 эмийн сангийн худалдан авах гэрээг дүгнэж 2 эмийн санд албан шаардлага хүргүүлэн ажилласан.

2023.02.27-ны байдлаар коронавируст халдварын батлагдсан тохиолдол гараагүй. Түргэвчилсэн шинжилгээнд 1059 хүн, ПСР шинжилгээнд 116 хүн хамрагдсан байна. Вакцинжуулалтанд:

1-р тунд 60929 хүн буюу 87.89 хувь /12-с дээш нас/

2-р тунд 57661 хүн буюу 83.28 хувь /12-с дээш нас/

3-р тунд 27389 хүн буюу 50.12 хувь /18-с дээш нас/

4-р тунд 2524 хүн буюу 5.78 хувь /18-с дээш нас/

Боловсрол

Архангай аймгийн баруун бүсийн англи хэлний багш нарт зориулсан чадваржуулах сургалтыг 2023 оны 2 дугаар сарын 11-ний өдөр Оюунсүндэр ОУБТ-ийн санхүүжилтээр Тариат сумын ЕБС дээр зохион байгууллаа. Тус сургалтад Хангай, Тариат, Цахир, Чулуут, Өндөр-Улаан сумдын багш нар, ментор багш нар 20 хүн оролцлоо.

Сургуулийн өмнөх боловсролын багш нарт 2022 оны 2 сарын 8-10-ны өдрүүдэд “Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн, зөвлөмж” онлайн сургалтыг Боловсролын ерөнхий газартай хамтран зохион байгууллаа. Уг сургалтад сургуулийн өмнөх боловсролын багш, эрхлэгч 300 гаруй албан хаагч хамрагдсан байна.

Насан туршийн боловсролын төв нь 18 байгууллагын 647 албан хаагчдад 8 төрлийн боловсрол олгох сургалтыг зохион байгууллаа.

Соёл

2023 оны 02 сарын 19 өдөр УИХ-ын гишүүн төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн Ч.Энх-Амгалан нар аймгийн соёлын байгууллагын ажилтан албан хаагчидтай танхимаар болон цахимаар уулзаж, цалин, нийгмийн асуудлаар албан хаагчдын саналыг сонсож ажиллалаа.

Музейн үзмэрийн 1733 дэсийн 3941ш үзмэр, 11 сумын Орон нутаг судлах танхимын 454 дэсийн 692ш үзмэрийг нэг бүрчлэн төрөл зүйлээр ангилан Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлэв.

2023 оны 02-р сарын 13-нд Соёлын өвийн үндэсний төвд сэргээн засварлах шаардлагатай Ууж, Цамын баг 2ш үзмэрийг, сан хөмрөгч Б.Баатархүүд холбогдох бичиг баримтын хамт хүлээлгэн өгсөн.

Нийгмийн хамгаалал

2023 оны 02 дугаар сард 15919 орчим тэтгэвэр, тэтгэмж авагчдад 8,1 тэрбум төгрөгийг хугацаанд нь олгожээ.

Нийгмийн даатгалын хэлтэсийн page хуудсанд 2023.02.27-ны байдлаар 35 мэдээ боловсруулж оруулсан. Давхардсан тоогоор 20,125 даатгуулагчдад мэдээллийг хүргэсэн бол 2269 даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

Засгийн газрын 2022 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын аварга малчин”, “Улсын хошой аварга малчин”, “Улсын аварга саальчин” шалгаруулах журмын дагуу 9 сумаас “Улсын аварга” малчин тодорч “Сар шинийн баяр”-ын өмнө шагналыг гардууллаа.

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/26 дугаар захирамжаар баталсан “Аймгийн аварга малчин, хошой аварга малчин, аварга саальчин, аварга хадланч шалгаруулах журам”-ын дагуу 19 сумын 98 аймгийн аварга малчин, 7 сумын 8 аварга саальчин, 10 сумын 11 Хошой аварга малчин, 3 сумын 5 аварга тариаланч, 2 сумын 2 аварга хадланч тус тус шалгарч, шагналыг гардууллаа.

МҮОНТ-ийн Ерөнхий захирлын 2018 оны А\08 тушаалын дагуу 24 малчин Алтан төлийн эзэн болж шагналыг гардуулах ажлыг зохион байгууллаа. Үүнд:

- Алтан унаганы эзнээр 8 сумын 9 малчин
- Алтан тугалын эзнээр 3 сумын 4 малчин
- Алтан тугалын эзнээр 9 сумын 9 малчин
- Алтан ишигний эзнээр 3 сумын 4 малчин

Энэ онд 19 сумын 101 багийн 8207 хот айлд 19.4 мянган малчин болон мал бүхий өрхийн 5.8 сая толгой мал өвөлжиж байна. Өнгөрсөн жил 1.9 сая толгой төл малыг бойжуулсан.

Аймгийн хэмжээнд 1.4 сая толгой малыг зах зээлд нийлүүлэхээр төлөвлөснөөс мал тооллогын дүнгээс харахад 1.6 сая толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулсан байна

Манай аймгийн зудын өндөр эрсдэлтэй Хангай, Цахир, Хашаат, Өгийнуур сумын зорилтот бүлгийн 40 өрхөд Нэгдсэн үндэсний байгууллага, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хамтарсан тусламжаас нэг өрхөд 450.0-750.0 мянган төгрөг, өрхийн охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн багц, малын амин дэм, эрдэст тэжээл, өвлийг өнтэй давах зөвлөмж, гарын авлага зэргийг олголоо.

Нийт мал сүргийн 1,0 хувь буюу 59864 толгой мал хорогдсон бөгөөд үүнээс Тэмээ 6 толгой буюу 0,35%, Адуу- 3423 толгой буюу 0.74%, Үхэр-11773 толгой буюу 1.45%, Хонь-22770 толгой буюу 0.74%, Ямаа-21712 толгой буюу 1,43 хувь нь хорогдсон байна. Үүнээс өвчнөөр 1404 толгой мал, 647 толгой хээлтүүлэгч мал хорогдсон байна. Том малын мал зүй бус хорогдлоор 32.1 мянган толгой мал хорогдсон байна.

Аймгийн хэмжээнд энэ онд 5,9 сая толгой мал өвөлжүүлж, хаваржуулах ба үүнээс улсын тусгай хамгаалалттай бүс нутагт Хангай, Чулуут, Булган, Цэнхэр, Тариат сумдын 310 өрхийн 194.8 мянган толгой мал өвөлжиж, хаваржиж байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дүгээр сарын 16-ны өдрийн А/04 дугаар тушаалаар зудын эрсдэл бүхий 10 суманд 80 тонн тэжээлийг хуваариллаа.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Барилга байгууламж, дэд бүтэц

Монгол улсын 2040 он хүртэлх “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах олон нийтийн хэлэлцүүлэг 2023 оны 02 дугаар сарын 14-

ны өдөр зохион байгуулагдаж БХБХ-ийн мэргэжилтнүүд хамрагдаж тус төсөлд санал хүргүүлэв.

Газрын биржийн цахим системээр 02 дугаар сарын байдлаар газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар эзэмшүүлэхээр Эрдэнэбулган суманд 4 байршил, Ихтамир сум 6 байршил, Хайрхан сум 4 байршил, Өндөр-Улаан сум 14 байршилд, Төсөл сонгон шалгаруулалтаар Эрдэнэбулган суманд 4 байршилд, Хайрхан сум 2 байршилд 3-р сард зохион байгуулагдахаар олон нийтэд мэдээлэл нийтэлсэн байна.

2023 оны 02 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрын төлбөрийн ногдуулалтыг төлбөр, татварын системд уншуулан тооцоолж 15.1 сая төгрөгийн нэхэмжлэлийг үүсгэн татварын нэгдсэн системд илгээсэн байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар 02 сард шинээр барилгын ажлын гэрээ хийгдээгүй бөгөөд 9 төрлийн барилга, байгууламжийн үнийн өсөлтийн гэрээнүүд хийгдсэн байна.

Аймагт барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч 20 аж ахуйн нэгж, байгууллагуудын 2022 оны тусгай зөвшөөрлийн мэдээлэл, үйл ажиллагааны цахим тайланг www.mcis.gov.mn сайтад байршууллаа.

Байгаль орчин

Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр Хайрхан суманд аюултай хог хаягдал (төрлийн хаягдал зай, батарей, ашиглалтгүй бүх төрлийн гар утас, повер банк, чихэвч, цэнэглэгч, жижиг зайт төхөөрөмжүүд, антибиотик, эм бэлдмэл)-ыг айл өрхүүдээс цуглуулах ажлыг бөмбөрцөгийн Сүмбэ байгууллагатай хамтарч зохион байгуулжээ. Энэ ажлаа үргэлжлүүлэн явуулахаар төлөвлөжээ.

Тариат сумын Мөрөн, Бөөрөлжүүт, Алтаад багт 42км урттай Аялал жуулчлалын шинэ маршрутыг төлөвлөжээ.

Лондоны амьтан судлалын нийгэмлэгтэй хамтран Булган сумын Хойд могойн гол-Тээлийн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хууль бус мод, ан амьтан агнах, хүрээлэн буй орчны гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх эргүүл шалгалтын ажлыг 2023 оны 02 дугаар сарын 13-17-ны өдөр зохион байгууллаа. Эргүүл шалгалтын ажилд БОАЖГ, Цэнхэр суман дахь сум дундын ойн анги, Булган сумын ЗДТГ, тус сумын Цагдаагийн хэсэг, Лондоны амьтан судлалын нийгэмлэгийн нийт 16 албан хаагчид оролцож, зөрчил үйлдэгдэх магадлалтай 4 чиглэлд 28 удаагийн эргүүл шалгалтын ажлыг хийсэн.

АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----